

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ

Төслийн нэр: Халдвартын тасагт жирэмсэн эхийн төрөх өрөөний багаж
тоног төхөөрөмжийг шинэчлэн тохижуулах

Төслийн дугаар: ОР-95/2020

Орхон аймаг
2020 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: **2020 оны 02 дугаар сарын 11-ны өдөр**

Тендер шалгаруулалтын нэр: **Халдвартын тасагт жирэмсэн эхийн төрөх өрөөни багаж тоног төхөөрөмжийг шинэчлэн тохижуулах**

Тендер шалгаруулалтын дугаар: **ОР-95/2020**

Орхон аймгийн ЗДТГ нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Халдвартын тасагт жирэмсэн эхийн төрөх өрөөний багаж тоног төхөөрөмжийг шинэчлэн тохижуулах** тухай цахим үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул (www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу.

Тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50000 /тавин мянган/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн саналыг **2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 08 цаг 00 минут**-аас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 02 дугаар сарын 20-ны 08 цаг 10 минутад** Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны **Сургалт мэдээллийн танхимд** нээнэ.

Дотоодын давуу эрх тооцохгүй.

Тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг Орхон аймгийн Орон нутгийн өмчийн газрын 70358570 утсаар авч болно.

Орхон аймгийн Орон нутгийн өмчийн газар
Нутгийн удирдлагын ордон 1 давхар 113 тоот өрөө
Утас:70358570

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа
 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт
 3. Тендерийн иж бүрдэл
- 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
 - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
- Үнийн санал маягтын дагуу баталгаажуулан ирүүлнэ.
 - Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтын дагуу, баталгаажуулан ирүүлнэ.
 - Улсын бүртгэлийн гэрчилгээний эх хувиас скайнердаж ирүүлэх
 - Шаардлагатай тусгай зөвшөөрлийн гэрчилгээний эх хувиас скайнердаж ирүүлэх Үүнд: **Эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх тусгай зөвшөөрөлтэй байх**
 - Захирлын цахим иргэний үнэмлэхний эх хувиас скайнердаж ирүүлэх
 - Компанийн танилцуулга ирүүлэх
 - Шүүхийн тодорхойлолт
 - Чадварын мэдээлэл / өмнө нь гүйцэтгэсэн ажлын туршлагын мэдээлэл, гэрээ, гэрээг дүгнэсэн акт ирүүлнэ.
 - Нийлүүлэхээр санал болгож буй барааны техник үзүүлэлт /техникийн дэлгэрэнгүй тодорхойлолт/-ыг захиалагчийн шаардсан техникийн тодорхойлолттой харьцуулж хүснэгтээр баталгаажуулан ирүүлэх
 - Нийлүүлэх барааны зургийг өнгөтөөр, харагдах байдал бүрэн тодоор ирүүлэх
 - Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг шалгах зорилгоор захиалагч болон ашиглагч байгууллага нь барааг шалгаж 7 хоногийн хугацаанд туршилтаар ажиллуулж үзэхийг зөвшөөрсөн тухай албан бичгийг тендерт оролцогч эх хувиар баталгаажуулан ирүүлнэ.
 - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.1-т заасан нөхцөл үүсээгүй тухай албан бичиг ирүүлэх
 - Тендерийн баримт бичгийн гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл эх хувиар ирүүлэх
 - Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ болон

- хугацаанд багтаан чанарын шаардлага хангасан барааг захиалагчид нийлүүлэх баталгааг бичгээр гаргаж ирүүлэх
- Баталгаат хугацаа олгох албан бичиг ирүүлэх /1 жилээс багагүй байх/
 - Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь техникийн тодорхойлолтод нийцсэн барааг бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан хугацаанд, газарт хүргэх үүрэгтэй ба барааг угсарч, суурилж өгөх тухай албан бичиг ирүүлнэ.
- 4. Тогтмол үнэ** 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд** 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
- 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа** 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх** 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл** 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

ТОӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<p>Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Шаардахгүй. Санхүүгийн тайланг тендерт хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн www.e-balance.mof.gov.mn-ээс тендерт оролцогчийн санхүүгийн тайлангаас борлуулалтын орлого, шаардлагатай мэдээллийг шалгана.</p> <p>Татварын тодорхойлолт: Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Татварын тодорхойлолт ирүүлэх шаардлагагүй бөгөөд Татварын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас тендерт оролцогчийн татварын өр, төлбөрийн талаарх мэдээллийг тендер нээсэн өдрийн байдлаар шалгах тул өр, төлбөргүй байх шаардлагатай.</p> <p>Туршлагын мэдээлэл /гэрээ, хүлээлгэн өгсөн акт ирүүлэх шаардлагатай./</p> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд:Эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх тусгай зөвшөөрөлтэй байх</p> <p>Эрүүл мэндийн яамны Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний эх хувиас скайнердаж ирүүлэх</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Тендерийн материалыг Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн ААН-ийн тоон гарын үсгийг ашиглан нэвтрэж цахим хэлбэр (PDF)-ээр илгээнэ. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50'000 /тавин мянган/ төгрөгийг www.tender.gov.mn-ээр банкны e-меркантийн системийг ашиглан төлнө.</p> <p>Сангийн сайдын 2019.12.09-ний өдрийн 255 дугаар тушаалаар батлагдсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын 3.5-т заасны дагуу Тендер хүлээн авах хугацаа нь Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй.</p> <p>Тендер хүлээн авах хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй. Тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийн хариуг Төрийн худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-ийн Тендерийн баримт бичгийн “ТОДРУУЛГА” хэсэгт байрлуулах тул тендерт оролцохыг сонирхогч этгээдүүдэд нэгэн зэрэг хүргүүлсэнд тооцно. Иймд тендерт оролцохыг сонирхогч этгээдүүд дээрх цахим сайтыг байнга шалгаж байхыг зөвлөж байна.</p> <p>Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл , баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт Adobe PDF шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлсэн бүх материал тод гаргацтай байх шаардлагатайг анхаарна уу. Уг шаардлагыг хангаагүй тохиолдолд тухайн тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>Тендерт оролцогч нь тендерийн материалд Хувь хүний нууцын тухай хууль болон Байгууллагын нууцын тухай хуулиар ил болгохыг хориглосон мэдээллийг ялгаж тусад нь ирүүлнэ.Тус файлын эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг</p>

	<p>нууцлахгүй ирүүлнэ. Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр Цаг: 08 цаг 00 минут</p>
ТӨЭЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд: ТЕНДЕРИЙГ ЦАХИМААР ДАРААХ ГАЗАРТ НЭЭНЭ. Байшин, гудамжны нэр: Орхон аймгийн ЗДТГ, Нутгийн Удирдлагын ордон Давхар болон өрөөний дугаар: Нэг цэгийн үйлчилгээ, Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны Сургалт мэдээллийн танхим Аймаг, хот: Орхон аймаг, Баян-Өндөр сум Улс: Монгол Улс Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: Огноо: 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр Цаг: 08 цаг 10 минут</p>
ТӨЭЗ 2.3	<p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Үнийн санал маягтын дагуу, баталгаажуулан ирүүлнэ. 2. Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтын дагуу, баталгаажуулан ирүүлнэ. 3. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ 4. Шүүхийн тодорхойлолт 5. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.1-т заасан нөхцөл үүсээгүй тухай албан бичиг ирүүлэх 6. Тендерийн баримт бичгийн гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл эх хувиар ирүүлэх 7. Баталгаат хугацаа олгох албан бичиг ирүүлэх /1 жилээс багагүй байх/
ТӨЭЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцгүй.</p>

БАТЛАВ:

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Д.СОЁЛЧХҮҮ

Гурав. **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

- 1. Барааны тодорхойлолт:** Нийлүүлэгдэх бараа нь дор дурьдсан техникийн тодорхойлолт, үзүүлэлт, тоо ширхэг хангасан байна.
- 2. Стандарт:** Нийлүүлэгдэх бараа ОУ-ын эсвэл гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна.
- 3. Баглаа, боодол:** Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодолыг стандартын дагуу хийж эцсийн цэгт хүргэнэ. Түүнээс гарах бүх эрсдлийг нийлүүлэгч хариуцна.
- 4. Бараа хүргэх газар:** Орхон аймгийн Бүсийн оношлогоо эмчилгээний төв
- 5. Шалгалт, туршилт:** Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч, эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, туршилт хийх эрхтэй. Шалгалт, туршилтыг барааг хүргэх газар буюу нийлүүлэх эцсийн цэгт явуулна. Шалгалт, туршилтаар бараа нь техникийн тодорхойлолтыг хангаагүй тохиолдолд захиалагч тус бараанаас татгалзах эрхтэй ба нийлүүлэгч тус барааг үнэ төлбөргүй солих эсвэл техникийн тодорхойлолттой нийцүүлэх бүхий л арга хэмжээ авна.

Барааны тодорхойлолт:

№	Барааны нэр	Хэмжих нэгж	тоо ширхэг	Техникийн тодорхойлолт
1	Өвчтөний хяналтын монитор	ширхэг	1	<p>о Дэлгэц: 12,1 инч өндөр нягтаршилтай мэдрэгчтэй TFT өнгөт LCD</p> <p>Стандарт үзүүлэлтүүд: ECG(7Lead), SpO2, NIBP, 1-Temp, Resp</p> <p>о Нэмэлтээр захиалах :ETCO2, 1-Temp, 4-IBP,ICO, принтер,VGA гаралт</p> <p>о Multi-Gas : CO2 ,O2,N2O, Hal,Enf,Iso,Des,Sevo. (Нэмэлтээр захиалах</p> <p>о Дэлгэцэнд хамгийн ихдээ 8 үзүүлэлтийн график харуулна.</p> <p>о цагын мэдээлэлийг хүснэгт болон график хэлбэрээр хадгална.</p> <p>о Хэл : English</p> <p>о Auto & Manual QRS detection, S-T segment, Arrhythmia detection, Pace Maker</p> <p>о Ажиллах горим : Насанд хүрэгчид, хүүхэд, нярай</p> <p>о NIBP хэмжих горим : Manual/AUTO/STAT, NIBP мэдээлэл хадгална.</p> <p>о Heart rate variability (HRV) буюу зүрхний цохилтын өөрчлөлтөнд анализ хийх функцтай.</p> <p>о Централ мониторийн системдхолбогдох боломжтой. (Wifi ,3G ,Lan)</p> <p>о AC/DC тэжээлд ажиллах боломжтой. Lithium батерейтай. Батерейгаар 3 цаг ажиллана.</p> <p>о Бүх үйлдлийг нэг товчлуур хийх боломжтой.</p> <p>Солонгос улсад үйлдвэрлэгдсэн эсвэл түүнтэй дүйцэх</p>

2	Төрөх эмэгтэйчүүдийн ор	ширхэг	1	Механик үйлдэлтэй байх, дугуйтай зөөж тээвэрлэх, Америк стандарт шаардлага хангасан.
3	Нярайн дулаацуулагч ширээ	ширхэг	1	/Амин үзүүлэлт хэмжигчтэй: пульс, дулаан, цусны даралт хэмжигчтэй\ Температурыг хянах системтэй. Аюулгүй байдлын дуут дохиололтой. Тэжээл: 110/220V 60/50Hz , Хэмжээ: 120см*70см*96см Температурыг хянах системтэй. Аюулгүй байдлын дуут дохиололтой. Тэжээл: 110/220V 60/50Hz , Хэмжээ: 120см*70см*96см ,
4	Билметр /Нярайн билирубин хэмжигч/	ширхэг	1	Bilimeter \MBJ20\ эсвэл түүнтэй дүйцэх • ЗЧАА батерейтэй, цахилгаан багассаныг илтгэх заалттай • Овор хэмжээ бага, өөр дээрээ цэнэглэгчтэй
5	Дуслын автомат шахуурга	ширхэг	1	Урсгалын хурдны хэмжээ 1 – 1000 мл /Шугаман Престатик / Түгээх эзэлхүүн 1 – 9999мл Нийт дуслын эзэлхүүн 1 – 9999мл Нарийвчлал $\pm 2\%$ -ийн дотор механизм дээр , $\pm 5\%$ -ийн дотор дуслын системээр Дохиолол (дуут болон гэрлэн): шугаманд агаар орох, бөглөрөлт, урсгалын алдаа(чөлөөт урсгал) амралтын горим, Вен нээлттэй үед, хаалга нээлттэй, цэнэг багасах, төхөөрөмжийн алдаа. Онцлон функц: товчлууруудын цоож, архив дахин харах, үлдэгдэл хугацаа, дохиолол давтах, нээлттэй систем, вен нээлттэй, шингэн чөлөөлөх, болус, бөглөрөлтийн түвшин, архив харах, дозын горим нэмэлтээр, сувилагчийн дуудлага, шинж чанарын цэс, төвийн систем-нэмэлтээр Жин: ойролцоогоор: 3.5 кг /дахин цэнэглэгдэх батарейгүйгээр/ Хэмжээ 100 х 190 х 250 мм Тэжээлийн чадал 40ВА Цахилгааны шаардлага AC 110/230В, 50/60Гц эсвэл DC 12В/24В, 2А Батарейн төрөл Ni-Cd дахин цэнэглэгдэх батарей Батарейн ажиллагаа 4 цаг(125мл/цагаар) Батарей цэнэглэгдэх хугацаа 6 цаг Ажиллагааны нөхцөл 10 - 40°C , 30-85% чийгшил/конденсацгүй нөхцөлд/ Хадгалах нөхцөл -10 - 45°C , 10-95% чийгшил/конденсацгүй нөхцөлд/ Багтаамж:0.1~1200мл, Нарийвчлал: $\pm 3\%$, Цэвэрлэх, Бөглөрөх, Буцааж үзэх, Тунгийн горим, Сувилагч дуудах зэрэг функцтэй.
6	Нярайн Судас тодруулагч	ширхэг	1	Цэнэглэж хэрэглэдэг, Атгадаг байх

7	Хүчил төрөгч өтгөрүүлэгч	ширхэг	1	Загвар: 7F-5 эсвэл түүнтэй дүйцэх Цахилгаан хангамж : $\sim 220V \pm 22V$, 50Hz ± 1 Hz Хэмжээ: 445 Ч 372 Ч 680мм Хүчилтөрөгчийн урсгал: 1~5L/min Хүчилтөрөгчийн концентраци : $\geq 90\%$ Жин : 28kg Оролтын чадал : 500Вт Гаралтын даралт : 30~70кРа Ажиллах үеийн шуугиан : ≤ 60 dB(A)
8	Амбуу /Том болон нярай/	ширхэг	2	Амьсгал дэмжих зориулалттай. Хүүхэд: багтаамж- 1000мл . Том хүн: багтаамж- 2000мл

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-Д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэх эгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Өвчтөний хяналтын монитор	<p>о Дэлгэц: 12,1 инч өндөр нягтаршилтай мэдрэгчтэй TFT өнгөт LCD</p> <p>Стандарт үзүүлэлтүүд: ECG(7Lead), SpO2, NIBP, 1-Temp, Resp</p> <p>о Нэмэлтээр захиалах :ETCO2, 1-Temp, 4-IBP,ICO, принтер,VGA гаралт</p> <p>о Multi-Gas : CO2 ,O2,N2O, Hal,Enf,Iso,Des,Sevo. (Нэмэлтээр захиалах</p> <p>о Дэлгэцэнд хамгийн ихдээ 8 үзүүлэлтийн график харуулна.</p> <p>о цагын мэдээлэлийг хүснэгт болон график хэлбэрээр хадгална.</p> <p>о Хэл : English</p> <p>о Auto & Manual QRS detection, S-T segment, Arrhythmia detection, Pace Maker</p> <p>о Ажиллах горим : Насанд хүрэгчид, хүүхэд, нярай</p> <p>о NIBP хэмжих горим : Manual/AUTO/STAT, NIBP мэдээлэл хадгална.</p> <p>о Heart rate variability (HRV) буюу зүрхний цохилтын өөрчлөлтөнд анализ хийх функцтай.</p> <p>о Централ мониторийн системдхолбогдох боломжтой. (Wifi ,3G ,Lan)</p> <p>о AC/DC тэжээлд ажиллах боломжтой. Lithium батерейтай. Батерейгаар 3 цаг ажиллана.</p> <p>о Бүх үйлдлийг нэг товчлууур хийх боломжтой.</p> <p>Солонгос улсад үйлдвэрлэгдсэн эсвэл түүнтэй дүйцэх</p>	1	ширхэг	Орхон аймгийн БОЭТ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
Төрөх эмэгтэйчүүдийн ор	Механик үйлдэлтэй байх, дугуйтай зөөж тээвэрлэх, Америк стандарт шаардлага хангасан.	1	ширхэг	Орхон аймгийн БОЭТ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
Нярайн дулаацуулагч ширээ	<p>/Амин үзүүлэлт хэмжигчтэй: пульс, дулаан, цусны даралт хэмжигчтэй\</p> <p>Температурыг хянах системтэй. Аюулгүй байдлын дуут дохиололтой. Тэжээл: 110/220V 60/50Hz , Хэмжээ: 120см*70см*96см</p> <p>Температурыг хянах системтэй. Аюулгүй байдлын дуут дохиололтой. Тэжээл: 110/220V 60/50Hz , Хэмжээ: 120см*70см*96см ,</p>	1	ширхэг	Орхон аймгийн БОЭТ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]

Билметр /Нярайн билирубин хэмжигч/	<p>Bilimeter \МВJ20\ эсвэл түүнтэй дүйцэх</p> <ul style="list-style-type: none"> • ЗЧАА батерейтэй, цахилгаан багассаныг илтгэх заалттай • Овор хэмжээ бага, өөр дээрээ цэнэглэгчтэй 	1	ширхэг	Орхон аймгийн БОЭТ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
Дуслын автомат шахуурга	<p>Урсгалын хурдны хэмжээ 1 – 1000 мл /Шугаман Престатик / Түгээх эзэлхүүн 1 – 9999мл Нийт дуслын эзэлхүүн 1 – 9999мл Нарийвчлал ±2%-ийн дотор механизм дээр , ±5%-ийн дотор дуслын системээр Дохиолол (дуут болон гэрлэн): шугаманд агаар орох, бөглөрөлт, урсгалын алдаа(чөлөөт урсгал) амралтын горим, Вен нээлттэй үед, хаалга нээлттэй, цэнэг багасах, төхөөрөмжийн алдаа. Онцлон функц: товчлууруудын цоож, архив дахин харах, үлдэгдэл хугацаа, дохиолол давтах, нээлттэй систем, вен нээлттэй, шингэн чөлөөлөх, болус, бөглөрөлтийн түвшин, архив харах, дозын горим нэмэлтээр, сувилагчийн дуудлага, шинж чанарын цэс, төвийн систем-нэмэлтээр Жин: ойролцоогоор: 3.5 кг /дахин цэнэглэгдэх батарейгүйгээр/ Хэмжээ 100 x 190 x 250 мм Тэжээлийн чадал 40ВА Цахилгааны шаардлага AC 110/230В, 50/60Гц эсвэл DC 12В/24В, 2А Батарейн төрөл Ni-Cd дахин цэнэглэгдэх батарей Батарейн ажиллагаа 4 цаг(125мл/цагаар) Батарей цэнэглэгдэх хугацаа 6 цаг Ажиллагааны нөхцөл 10 - 40°C , 30-85% чийгшил/конденсацгүй нөхцөлд/ Хадгалах нөхцөл -10 - 45°C , 10-95% чийгшил/конденсацгүй нөхцөлд/ Багтаамж:0.1~1200мл, Нарийвчлал: ±3% , Цэвэрлэх, Бөглөрөх, Буцааж үзэх, Тунгийн горим, Сувилагч дуудах зэрэг функцтэй.</p>	1	ширхэг	Орхон аймгийн БОЭТ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
Нярайн Судас тодруул агч	Цэнэглэж хэрэглэдэг, Атгадаг байх	1	ширхэг	Орхон аймгийн БОЭТ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
Хүчил төрөгч өтгөрүүлэгч	<p>Загвар: 7F-5 Цахилгаан хангамж : ~220V±22V, 50Hz±1Hz Хэмжээ: 445 Ч 372 Ч 680мм Хүчилтөрөгчийн урсгал: 1~5L/min Хүчилтөрөгчийн концентраци : ≥ 90% Жин : 28kg Оролтын чадал : 500Вт Гаралтын даралт : 30~70kPa Ажиллах үеийн шуугиан : ≤60dB(A)</p>	1	ширхэг	Орхон аймгийн БОЭТ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]

Амбуу /Том болон нярай/	Амьсгал дэмжих зориулалттай. Хүүхэд: багтаамж- 1000мл . Том хүн: багтаамж- 2000мл	2	ширхэ г	Орхон аймгий н БОЭТ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноо с хойших хугацааг бичих]
----------------------------------	---	---	------------	------------------------------	----------	----------	--

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

**ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Д.СОЁЛЧХҮҮ ТАНАА**

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|--|-------|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [моо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан моо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
- 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
Барааг хүлээн авах комисс шалгаж, туршиж актаар хүлээн авна. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч, эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, туршилт хийх эрхтэй. Шалгалт, туршилтыг барааг хүргэх газар буюу нийлүүлэх эцсийн цэгт явуулна. Шалгалт, туршилтаар бараа нь техникийн тодорхойлолтыг хангаагүй тохиолдолд захиалагч тус бараанаас татгалзах эрхтэй ба нийлүүлэгч тус барааг үнэ төлбөргүй солих эсвэл техникийн тодорхойлолттой нийцүүлэх бүхий л арга хэмжээ авна.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5)
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага. **Баталгаат хугацаа 1 жилээс багагүй байна.**
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7)
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
Гэрээний үнэ төгрөгөөр төлөгдөнө.
Урьдчилгаа төлбөр: Олгохгүй.
Бараа ачигдсаны дараа төлөх төлбөр: Олгохгүй.
Барааг хүлээн авч акт үйлдсэний дараа төлөх: Захиалагчийн хүлээн авсан тухай актыг үндэслэн төлбөрийг 100 хувь олгоно.
- Гэрээний үнийн дүнгийн [моо]¹ хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)²
- a. Алданги оногдуулах хувь: Гэрээний үнийн дүнгийн 0,1 хувиар ööääöää öüüüöüü öî í î äöóòäî ä öî î öî æäüüüü éé çí èèäáóóöóöéí à.
- b. Алдангийн нийт дүн: Алдангийн дээд хязгаар нь гэрээний нийт дүнгийн 10 хувь байна. Дээд хязгаар хэтэрсэн тохиолдолд захиалагч тал гэрээг цуцална.

¹ Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

² Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁴;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

³ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

⁴ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]